



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг



ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ХҮНИЙ ЭРХ:
Агаарын бохирдол, шинжлэх ухааны нотолгоо, шийдэл
Эрдэм шинжилгээ, технологийн хурал

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ

2023 ОНЫ 02 САРЫН 07, МЯГМАР ГАРАГ

**БАЙРШИЛ: МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ТӨВ БАЙР
ЭРДМИЙН ТАНХИМ**

Огноо: 2023.02.07 Мягмар гараг

Хугацаа: 08:30-18:00

Байршил: МУИС-ийн Төв байр, Эрдмийн танхим

Онлайн оролцох:

Join Zoom Meeting

<https://unicef.zoom.us/j/96791999707>

Password: 110326

Хуралд бүртгүүлэх, холбоо барих:

Ц. Соёл-Эрдэнэ: soyolerdene@seas.num.edu.mn

М. Жавзандулам: jmyagmar@unicef.org



Scan me!

Онлайн бүртгүүлэх:

“Эрүүл, аюулгүй орчинд амьдрах хүний эрх: Агаарын бохирдол, шинжлэх ухааны нотолгоо, шийдэл” эрдэм шинжилгээ, технологийн бага хурлын бүртгэл (google.com)

Зохион байгуулагч, түнш байгууллага:

- Байгаль орчин, аялал жуулчлалын яам
- Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо
- НҮБ-ын Хүүхдийн Сан
- Монгол Улсын Их Сургууль
- Швейцарын Хөгжлийн Агентлаг
- Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА.

Оролцогчид: Засгийн газар /яам, агентлаг, нийслэл, аймаг/, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөлөгчид.

Зохион байгуулалт: танхимаар, онлайн хэлбэрээр.

- Илтгэл, хэлэлцүүлэг
- Эрдэм шинжилгээний ажлын ханан илтгэл
- Инженер, технологийн шийдлийн үзүүлэн танилцуулга.

Удиртгал

Монгол Улс Алсын хараа–2050 хөгжлийн үрт хугацааны бодлого /2020/, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр /2017/ зэрэг бодлогын баримт бичигт хөгжлийн тулгамдсан асуудлын нэг болоод байгаа агаарын бохирдлыг бууруулж, эрүүл, аюулгүй орчинд амьдрах хүний эрхийг хангах бодлогоо тодорхойлон хэрэгжүүлж байгаа билээ.

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газар 2019 оны 5-р сарын 15-аас Улаанбаатар хотод түүхий нүүрс хэрэглэхийг хориглож, мөн гэр хороололд цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг үзүүлж, халаалтаа цахилгаанаар шийдэх боломжийг нэмэгдүүлэх, халаалтын уурын зуухны

янданд шүүлтүүр суурилуулах зэрэг тодорхой шат дараалсан арга хэмжээнүүд авсны үр дүнд Улаанбаатар хотын агаар дахь тоосонцрын хэмжээ 40 хүртэл хувиар буурсан үр дүнд хүрсэн.

Гэвч Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж нэмэгдсэн, мөн Орхон, Ховд, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл, Өмнөговь зэрэг аймгийн төвийн агаарын бохирдлын асуудал тулгамдсан хэвээр байгаа нь хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд ялангуяа эх, хүүхэд, өндөр настан нийгмийн эмзэг бүлгүүд агаарын бохирдолд илүү өртөж байна.

2022 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/227, 21/06 2022 тоот тушаалаар “Агаарын бохирдлын чиглэлээр хэрэгжүүлэх эрдэм шинжилгээний ажлын тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөө 2025” баталж,

- Агаарын бохирдлын талаарх бодлого, эрх зүйн судалгаа
- Агаарын бохирдлын мониторинг
- Агаарын бохирдлын эх үүсвэр
- Агаарын бохирдлыг бууруулах инженер, технологийн шийдэл, арга хэмжээний үнэлгээ
- Агаарын бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл ба өртөлт
- Агаар бохирдуулах бодис гэсэн зургаан чиглэлийн хүрээнд 21 сэдэвт судалгааны ажлыг 2022-2025 онд хэрэгжүүлэхээр тусгасан юм.

НҮБ-ын Хүүхдийн Сан нь Монгол Улсын Засгийн Газартай хамтран, Швейцарын Хөгжлийн Агентлагтай хамтран хэрэгжүүлж байгаа “Эх, хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөөг бууруулах нь” хөтөлбөрийн хүрээнд агаарын бохирдлын чиглэлээр 23 судалгаа, үнэлгээний ажлыг санхүүжүүлж, Засгийн газрын агентлаг, олон улсын болон үндэсний их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн юм.

Зорилго

Агаарын бохирдлын чиглэлээр сүүлийн жилүүдэд гүйцэтгэсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, баримт, нотолгоо, Монгол Улсад нэвтрүүлэн хэрэгжүүлж байгаа технологийн шийдлийг танилцуулж, агаарын бохирдлыг бууруулах бодлого, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг эрүүл, аюулгүй орчинд амьдрах хүний эрхийг хамгаалах асуудалтай уялдуулан дүгнэх зорилготой. Түүнчлэн, агаарын бохирдлыг бууруулах техник, технологийг нэвтрүүлэх, дэлгэрүүлэхэд шаардлагатай техникийн туслалцаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр гарсан саналуудыг нэгтгэн дүн шинжилгээ хийж, НҮБ-ын Ази, Номхон Далайн Эдийн Засаг, Нийгмийн Хамтын ажиллагааны Комисс, Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн хамтарсан “[Цэвэр Агаар](#)” [дээд хэмжээний үүлзалтын](#)¹ хэлэлцэх асуудалд тусгаж, оролцогч талуудтай мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг өргөтгөхөд хувь нэмрээ оруулах юм.

¹ <https://www.unescap.org/events/High-Level-Forum-Clean-Air>

Хөтөлбөрийн төсөл

Цаг	Байршил: МУИС-ийн Эрдмийн танхим
8:30-9:00	Бүртгэл, цай/кофе
9:00-09:30	Нээлтийн ажиллагаа
	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б. Бат-Эрдэнэ - Хамтын ажиллагааны газрын дэд дарга, Швейцарын хөгжлийн агентлаг Бенуа Мейэр-Биш - МУИС-ийн захирал Проф. Д. Бадарч - НҮБ-ын Хүүхдийн Сангийн Суурин Төлөөлөгч Еваристе Коуасси Комлан - ЖАЙКА Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга Танака Шиничи <p>Эрдэм шинжилгээний хурлын зорилт.</p>
09:30-11:00	Салбар хуралдаан 1: Агаарын бохирдлын эх үүсвэр, мониторинг
	<ul style="list-style-type: none"> • Илтгэл: 5 (Илтгэл тус бүр 15 мин, нийт 60 мин) • Эрдэм шинжилгээний ханан илтгэлийн хураангуйлж танилцуулах (10 мин) • Асуулт, хариулт, дүгнэлт (20 мин)
11:00-11:15	Цайны завсарлага
11:20-13:00	Салбар хуралдаан 2: Агаарын бохирдлын нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн нөлөө
	<ul style="list-style-type: none"> • Илтгэл: 4 (Илтгэл тус бүр 15 мин, нийт 60 мин) • Панел хэлэлцүүлэг (20 мин) • Асуулт хариулт, дүгнэлт (20 мин)
13:00-14:00	Өдрийн хоол (MG Grill, Галлерия)
Цаг	Байршил: Галлерия, MG хурлын танхим
14:00-16:00	Салбар хуралдаан 3: Инженер, технологийн шийдэл, бодлогын дэмжлэг
	<ul style="list-style-type: none"> • Инженер, технологийн илтгэл: 4 (Илтгэл тус бүр 15 мин, нийт 60 мин) • Технологи, инновацын танилцуулга (10 хүртэлх шийдэл, тус бүр 2 минутын видео танилцуулга, нийт 20 мин) • Технологийн шийдлийн хэлэлцүүлэг, экспертийн үнэлгээ (20 мин). • Технологийн шийдлийг бодитоор хэрэгжүүлэх бодлогын дэмжлэг (20мин) <p><i>Технологийн шийдлийн үзүүлэн танилцуулга: Үзэсгэлэн байдлаар зохион байгуулах, технологийн үзүүлэн танилцуулгыг аж ахуйн нэгж, байгууллага нь зураг/дүрс, видео, биет хэлбэрээр танилцуулна.</i></p> <p><i>Өөртөө үйлчлэх халуун цай, кофе хуралдааны туршид байна.</i></p>
16:00-16:40	Хурлын үр дүнгийн хэлэлцүүлэг
	<ul style="list-style-type: none"> • Хурлаас гарах санал, санаачилгыг хэрэгжүүлэх арга зам • “Цэвэр агаар” өндөр хэмжээний олон улсын чуулга уулзалтын хэлэлцэх асуудалд тусгах саналын төсөл.
16:40-17:00	Хурлын хаалтын ажиллагаа